



Published in the Russian Federation
 Oriental Studies (Previous Name: Bulletin of the Kalmyk Institute for
 Humanities of the Russian Academy of Sciences)
 Has been issued as a journal since 2008
 ISSN: 2619-0990; E-ISSN: 2619-1008
 Vol. 39, Is. 5, pp. 152–165, 2018
 DOI 10.22162/2619-0990-2018-39-5-152-165
 Journal homepage: <https://kigiran.elpub.ru>

УДК 811.512.3

Частотность и применение некоторых терминообразующих суффиксов монгольского языка

Гэрэлма Гёрёчин¹

¹ доктор наук, профессор, руководитель отдела прикладной лингвистики, Институт языка и литературы, Академия наук Монголии (13330, Монголия, г. Улан-Батор, пр. Жукова, 54А).
 ORCID: 0000-0001-53160233. E-mail: g_mgl2003@yahoo.com

Аннотация

В данной статье автор исследовал значение, функции, применение и частотность некоторых суффиксов, а именно: *-тан*⁴, *-нцар*², *-гана*⁴, *-лзай*³, *-жс*, *-жсин*, *-ч*, *-чин*, *-ийнхан*², которые, хотя и активно участвуют в образовании новых слов, пополняя тем самым лексический запас монгольского языка, при терминообразовании несут в себе несколько другие, специфические функции и отличаются частотой своего употребления. В исследовании были привлечены термины естественных наук, таких как ботаника, зоология, минералогия, география и т. д., выбранные из «Русско-монгольского терминологического словаря» (объем — 120 000 терминов).

Данное исследование проведено в двух основных направлениях. Во-первых, автор обобщает исследования ученых, изучавших значение вышеперечисленных суффиксов, и на основе сопоставления, выделяет среди перечисленных выше суффиксов наиболее продуктивные с точки зрения терминообразования.

Ученый Т. А. Бертагаев в свое время отмечал, что суффикс *-тан*⁴ несет в себе: 1) коллективно-множественное значение: *цэргийн эрхтэн* 'военщина, милитаристы'; 2) значения единичности и множественности: *цагаантан* 'белогвардейцы, белогвардеец'; 3) значение, указывающее на объект единичного: *сэхээтэн* 'интеллигенция'. Однако при терминообразовании суффикс *-тан*⁴ приобретает собирательное значение и широко используется в названиях видов животных и растений. Например: в названии животных — *битүү тууртан* 'непарнокопытные' (1); в названии растений — *луулийн язгууртан* 'маревое семейство'; в названии микроорганизмов — *багц шилбүүртэн* 'лофотрихи' (1); в названии птиц — *дэвүүр сүүлт жигүүртэн* 'птицы веерохвостые' и т. д.

Суффикс *-нцар*, кроме своего основного диминутивного значения, например: *үндсэнцэр* 'корешки', *навчинцар* 'листочки' (7) и т. д., при образовании терминов привносит значение схожести, например: *манинцар* 'гермафродитизм' (3), *болронцор чулуу* 'кварцит' (2), а также указывает на составную часть целого, например: *элэгний хэлтэнцэр* 'долька печеночная' (2).

В своём исследовании автор, тщательно проанализировав терминообразовательную функцию суффикса *-гана*⁴, который в научных трудах упоминается как суффикс, образующий в основном названия животных и растений, выявил 5 новых значений, расширивших его семантику. К ним относятся:

а) основная словообразовательная функция, которая заключается в присоединении данного суффикса к корню слова и образовании, на основе присущих ему характерных признаков, новых существительных. Данная особенность этого суффикса весьма традиционна

в терминообразовании. Например: *улаагана* ‘смородина красная лесная’ (3), *хонхорт харгана* ‘чингиль серебристый’ (3) и т. д.;

б) при помощи настоящего суффикса отображаются форма и конфигурация животных, растений, и на основе этого образуются термины с номинативным значением. Например: *өргөст бударгана* (*өргөст хамхуул*) ‘солянка сборная мясная’ (2), *сархитгана* ‘полевка обыкновенная’ (серая) (2);

в) образование терминов путем присоединения данного суффикса к корням звукоподражательных слов, таких как: *цүүр цүүр хийх*, *хэд хэд хийх*. Например: *цүүргэнэ* ‘саранча’ (3), *хэдгэнэ* ‘шмель’ (3) и т. д.;

г) посредством присоединения этого суффикса к существительным образуются сходные данному виду термины. Например: *сүүгэнэ* ‘молочай’ (1), *салаагана* ‘хориспора’ (2), *гичгэнэ* ‘лапчатка гусиная’ (1);

д) названия растений и рыб с суффиксом *-гана*⁴, имеющие в своей основе иноязычные, омонголизированные слова. Например: *тавилгана* (*раст.*) ‘таволга’ (1), *суладай*, *нагана* ‘нагана’ (*раст.*) (1) и т. д.

Во-вторых, автором ставилась цель при помощи программы TextStat вычислить частотность суффиксов *-тан*⁴, *-нцар*², *-гана*⁴, *-лзай*³, *-жс*, *-жсин*, *-ч*, *-чин*, *-ийнхан*². Исследование, проведенное автором, показало, что в «Русско-монгольском терминологическом словаре» (120 000 терминов) суффиксы *-т*, *-тан*⁴ в составе односоставных (*амьтан* ‘живые существа’, *боргоцойтон* ‘шишконосные’) и сложносоставных (*нийлмэл цэцэгтэн* ‘сложноцветный’, *сарьсан далавчтан* ‘перепончатокрылые’) слов встречаются 292 раза. Суффикс *-нцар*² (*бөөлжүүлэх чулуунцар* ‘рвотный камень’, *балнадын савханцар* ‘тифозная палочка’ и т. д. — 218 раз; суффикс *-гана*⁴ (*гялгана* (*рыба*) ‘чебак’, *явган тургана* ‘шелковица белая’) и т. д. — 68 раз; суффиксы *-ч*, *-чин* (*агтач* (*адуучин*) ‘конюх’, *алимны балч шавьж* ‘медвежати́на яблочная’) — 53 раза; суффиксы *-жс*, *-жсин* (*асмалжсин занар* ‘сланец диоритовый’, *молоржсин* ‘топазолит’) — 45 раз и, наконец, суффикс *-ийнхан* (*азийнхан* ‘азиаты’, *суунга ёроолынхон* ‘сиенит’) — 11 раз.

Ключевые слова: словообразовательные суффиксы, образующие термины, частотность употребления суффиксов, прикладная лингвистика, изменение значения

Монгол хэл нь залгамал хэл бөгөөд шинэ үг бүтэх тогтолцооны үндсэн шинж нь язгуурын араас үг бүтээх дагавар залгаж үгийн сангийн шинэ үг бүтээдэг зүй тогтолтой.

Үг бүтээх дагаврын утга нь шинэ нэр томьёо бүтээхэд өргөжих, явцуурах, идэвхжих олон шинж чанар нэр томьёог тогтолцоотой тогтоож ирсэн 90 гаруй жилийн туршид тогтоосон хэлний баримтаас харагдаж байна. Иймээс бид нэр томьёоны өвөрмөц үүрэгтэй болсон цөөн дагаврыг сонгон авч 120,000 нэр томьёог багтаасан «Орос монгол нэр томьёоны толь» 3 ботиос давтамжийг тодорхойлон утга, хэрэглээний байдлыг тодруулан судлах болно [ОМНТТ 1964; 1970; 1979].

Бидний авсан жишээ ургамал, амьтан, чулуулаг зэрэг байгалийн ухаанд хамаарах тул эдгээр салбаруудын нэр томьёо бүтээх дагавруудын талаар судласан юм.

*-тан*⁴ дагавар

Монгол хэлний *-тан*⁴ дагаврын талаар судалгааны бүтээлүүдэд тус дагаврыг

нэрийн үндсэнд залгаж уул зүйлийн хам олны санааг илтгэсэн жинхэнэ нэр үүсгэнэ. Жишээ нь: ‘араатан, жигүүртэн, туурайтан’ гэх мэт. Мөн уул нэрийн үндсээр илэрч буй утгыг эзэмдэхийн санааг илтгэнэ. Жишээ нь: ‘эрдэмтэн, оюутан’ гэх мэт. Зарим үед хамт олны санаа нь алдагдаж нэгж ухагдахууныг илтгэсэн ч байдаг. Жишээ нь: ‘амьтан, мэргэжилтэн’ гэх мэт [Орчин цагийн монгол хэл 1966: 78].

«<...> Тухайн зүйлийг эзэмшсэн, бүхий хам олны утга. Жишээ нь: оюу(н)тан, сэхээтэн, ажилтан, ... ястан гэх мэт.

— Нийгмийн хам олныг заасан утга. Жишээ нь: амьтан, араатан, ялаатан, цохтон... гэх мэт.

— Хүндэтгэлийн утга. Жишээ нь: багштан, гэгээнтэн, ... ахайтан, дээдэстэн гэх мэт.

— Нийгмийн хам олны үзэл, үнэлэмж зэргээр нь ялгасан утга. Жишээ нь: улаатан, баруунтан, өшөөтөн гэх мэт. Энэ дагаврыг дарга, даамал, захирал, эрх, дарх, тушаал, ямандаг зэрэг үгэнд залгахад ихэвчлэн сөрөг сэтгэлийн байдал илэрдэг байна. Жишээбэл:

... даргатаан ... гэх мэт.

— Идэвхгүй язгуурт залгаж нэр үг бүтээнэ. Жишээ нь: ной-тон, уй-тан, хүй-тэн гэх мэт» [Чоймаа 1997: 167; Мөнх-Амгалан, Кан Шин 2014: 27].

Эрдэмтэн Т. А. Бертагаев: 1. хам олны утгатай: цэргийн эрхтэн 'военщина, милитаристы'; 2. ганц ба олны утгатай: цагаантан 'белогвардейцы, белогвардеец'; 3. ганцын юмыг заасан утгатай: сэхээтэн 'интеллигенция' [Бертагаев 1964] гэж тодорхойлсон байна.

Байгалийн шинжлэх ухаанд *-тан*⁴ дагавраар нэр томьёо бүтээсэн цөөнгүй бий.

Энд дурдсан утгаас амьтан, ургамлын нэр томьёонд: үетэн 'злак' [УНТКМ 1962: 5], тосны загалмайтан 'крестоцветные масличные культуры' [УНТКМ 1962: 7], урт далавчтаны баг 'длиннокрылые' [ОМНТТ 1979 III: 149], ойн аймагтан 'папоротниковые' (640) гэхчилэн хам олны утгаар өргөн хэрэглэж байна.

Амьтан судлаач С. Дуламцэрэн ангилбарын зиндааны нэрийг ийнхүү «АНГИ-ийг -ууд² (дэлэнтнүүд), БАГ-ийг *-тан*⁴ (мэргэчтэн, туруутан, туулайтан) төгсгөлтэй байхаар жигдлэв» [Дэлэнтний ангилал зүй 2003: 9] гээд гар далавчтаны баг 'рукокрылые', хос туурайтны баг 'парнокопытные' гэх зэргээр бүтээлдээ тусгасан бөгөөд «...ургамлын овгийг энэ дагавраар хэлбэржүүлэн ижилсүүлэх нь чухал байгаа»-г онцлон бичжээ. Уг салбар ухаан дотроо баг болон овгийн алиныг нь *-тан*⁴ дагавраар хэлбэржүүлэхээ жигдлэх аваас энэ нь нэр томьёог хураангуй болгох оновчтой жигдрүүлэлт болох талтай.

Монгол хэлний нэр үгээс нэр үг бүтээх *-тан*⁴ дагаврын талаар «Орчин цагийн монгол хэл» бүрэн хэлзүйд оруулснаас гадна эрдэмтэн Т. А. Бертагаев [Бертагаев 1974: 150–154], Л. Болд [Болд 1986: 18] нар тухайн дагаврын үүсэл, гарал утгыг нарийвчлан судалжээ.

Бид судалгаандаа 120,000 орчим нэр томьёог багтаасан «Орос-монгол нэр томьёоны толь» гурван боть толийг хэрэглэгдэхүүн болгож, улмаар TextStat программаар тооцоолон судалгаа хийхэд «Орос-монгол нэр томьёоны толь» I боть-д [ОМНТТ 1964]:

Амьтан 'живые существа' (1)¹

Ан, араатан, ан гөрөөс 'зверь' (1)

¹ (1), (2), (3) — хэмээх нь «Орос-монгол нэр томьёоны толь» гурван ботийн алинд буйг заасан тэмдэг.

Битүү тууртан 'непарнокопытные' (1)
Луулийн язгууртан 'маревое семейство'
Лууль 'лебеда' (1)

Махчин, араатан 'хищные' (1)

Нугалмайтан 'позвоночное или черепное' (1)

Анх тэжээлтэн 'прототрофы' (1)

Анх ургамал 'протофит' (1)

Багц шилбүүртэн 'лофотрихи' (1)

Бичил биетэн 'микроорганизм'

Бичил бөм 'микрококк' (1)

Булцуу үртэн 'клубнеплод' (1)

Булчин 'мышца' (1)

Иж тэжээлтэн 'паратрофы' (1)

Өөсөөн тэжээлтэн 'аутотроф' (1)

Савар жигүүртэн 'рукокрылые' (1)

Тойрон шилбүүртэн 'перитрихи' (1)

Үндэс үртэн 'корнеплод' гэх мэтээр 41 удаа дангаараа байх боловч «амьтан» хэмээх үгтэй давхардсан нь 21 удаа, нийт 62 удаа уг *-тан* дагавар бүхий дан болоод нийлмэл нэр томьёо бүртгэгдсэн.

«Орос-монгол нэр томьёоны толь» II боть-д [ОМНТТ 1970]:

Далан түрүүтэн 'волчниковые'

Донгодогч шар жигүүртэн 'сорокопут длиннохвостый' (3)

Тогосголжин жигүүртэн 'аргусовые птицы'

Дэвүүр сүүлт жигүүртэн 'птицы веерохвостые'

Доод хавч хэлбэртэн 'рак низший'

Доод хавчин дүрстэн 'низшие ракообразные' (6)

Дээд хавч хэлбэртэн 'рак высший'

Дээд хавчтан 'высшие ракообразные'

Дутуу гэдэстэн 'турбеллярий бескишечный'

Заримдаг шүдтэн 'неполнозубые'

Зургаан тэнхлэгт хөвөн биетэн 'губки шестилучевые'

Илд сүүлтэн (үет хөлт амьтан) 'мечехвосты'

Могой сүүлтэн 'змеихвостки'

Нийлмэл цэцэгтэн 'сложноцветный' гэх мэтээр хамгийн олон *-тан*⁴ дагавар бүхий 186 нэр байна. Энэ нь уг толь бусдаасаа хэмжээгээрээ том, багтаамжтай байдагтай холбоотой.

«Орос-монгол нэр томьёоны толь» III боть-д [ОМНТТ 1979]:

Салс спортон 'споровики слизистые'

Хольцтоны хэв шинж 'тип колчедана'

Шилбүүр хөлтөн 'паукообразные-жгутоногие'

Дээд хөхтөн 'высшие млекопитающие'

Арван хөлтөн 'головоногие — десятиногие'
 Найман хөлтөн 'головоногие — восьминогие'
 Онгоцтой толгой хөлтөн 'головоногие — наутилиды'
 Толгой хөвтөн 'головохордовые' гэх зэргээр 54 удаа *-тан*⁴ дагавартай нэр томьёо тохиолдоно.

Эндээс дүгнэж үзвэл, «Орос-монгол нэр томьёоны толь» гурван ботид нийтдээ *-тан*⁴ дагавартай нэр томьёо 292 байна.

Дан үгэнд *-тан*⁴ дагавар залгаж нэр томьёо бүтээсэн

Амьтан 'живые существа' (1)
 Боргоцойтон 'шишконосные' (2)
 Бүрхүүлтэн 'облочники' (3)
 Гавалтан 'черепные' (3)
 Гургуултан 'фазаны' (3)
 Гуурстан 'сифонофоры' (2)
 Зэржгэнэтэн 'славковые' (3)
 Сахалгүйтэн (шавьж) 'бессяжковые' (2) ?
 Спортон 'споровики' (3)
 Тодолтон 'скворцовые' (3)
 Үетэн 'злаковые' (2)
 Хортон 'задира' (2)
 Хөлгүйтэн 'безногие' (2)
 Хилэнцтэн 'паукообразные скорпионы' (2)
 Хуягтан 'панцырные' (3)
 Шилбүүртэн 'биченосцы' (2)
 Шүхэртэн 'зонтичные' (2)

Эрүүгүйтэн 'бесчелюстные' (2) хэмээн давхардаагүй тоогоор 17 удаа тохиолдож буйг уг дагавартай нэр томьёотой харьцуулвал цөөн байна.

Харин нийлмэл үгийн бүтцэд орсон *-тан*⁴ дагавартай нэр томьёо 270 гаруй байх агаад далавчтан хэмээх нэр томьёотой нийлэмж 17 удаа, спортон хэмээхтэй нийлэмж 6 удаа байх жишээтэй.

Уг дагавар нь хоршоо болон нийлэмж үгийн ард орж үгийн сангийн шинэ утгатай нэр томьёо бүтээж буй нь үг бүтээх задлаг болон нийлэг аргыг нэгэн үгийн бүтцэд багтаан хэрэглэсэн өвөрмөц үзэгдэл болно.

А. Тэмдэг нэрийг нэр үгэнд үндсээр хамжуулан холбосон ац туурай, нийлмэл, цэцэг, сарьсан далавч зэрэг нийлэмж үгэнд *-тан*⁴ дагавар залган дараах нэр томьёог бүтээсэн нь хамгийн бүтээлч шинжтэй.

Ац туурайтан 'парнокопытный' (1)

Нийлмэл цэцэгтэн 'сложноцветный' (2)

Сарьсандалавчтан 'перепончатокрылые' (3)

Илүү хуруутан 'полидактилия' (2)

Элдэв шүдтэн 'разнозубые' (2)

Б. Тооны нэр болох ганц, хос, гурав, зургаа, найм, арав гэх мэт үгийг нэр үгэнд үндсээр хамжуулан холбосон ганц идэш, хос загалмай, ганц сүв зэрэг нийлэмж үгэнд *-тан*⁴ дагавар залгаж бүтээсэн нэр томьёо цөөнгүй.

Ганц идэштэн 'монофага' (2)

Ганц сүвтэн 'однопроходные' (2)

Хос сүвтэн 'парноопоровые' (2) ?

Хос сүүлтэн 'двухвостик' (2)

Хос эвэртэн 'двурогий' (2)

Хос заламгайтан, жинд заламгайтан 'пластинчатожаберные' (3)

Жинд заламгайтан — Гурван шивнүүртэн үхэр бөднө 'трехперстки' (3)

Зургаан тэнхлэгт хөвөн биетэн 'губки шестилучевые' (2)

Найман хөлтөн 'головоногие-восьминогие' (1)

Арван хөлтөн 'головоногие-десятиногие' (1)

В. *-т*, *-гүй* дагавартай үүсмэл тэмдэг нэрийг нэр үгэнд захируулан холбох гэх мэтээр үүссэн нийлэмж үгэнд *-тан*⁴ дагавар залгаж нийлмэл нэр томьёо бүтээж байна.

Ихэсгүй амьтан 'аплацентальные животные; животные аплацентарные' (2)

Уст бүрхүүлтэн 'амниота' (2)

Ойм хэвт үртэн 'папоротникообразные семенные' (3)

Дэвүүр сүүлт жигүүртэн 'птицы веерохвостые' (3)

Суумал нүдтэн хөлтөн 'брюхоногие сидячеглазые' (2)

Г. Өөр хоорондоо харьяалахын тийн ялгалаар холбогдсон нэрийн холбоо үгийн ард *-тан*⁴ дагавар залгаж бүтсэн нийлмэл нэр томьёо байна.

Анхны шилбүүртэн 'биченосцы первичные' (2)

Луулийн язгууртан 'маревое семейство' (1)

Янз бүрийн идшийн амьтан 'многоядные животные' (2)

Тэргүүлэгч цэцэгтэн 'розовые' (2) гэх зэрэг нийлэмж үгэнд *-тан*⁴ дагавар залган үүссэн нэр томьёо байна.

Монгол хэлний *-тан*⁴ дагаврын утгыг нэрийн үндсэнд залгаж уул зүйлийн хам олны санааг илтгэсэн жинхэнэ нэр үүсгэнэ. Жишээ нь: 'араатан, жигүүртэн, туурайтан' гэх мэт. Мөн уул нэрийн үндсээр илэрч буй утгыг эзэмдэхийн санааг илтгэнэ. Жишээ нь: 'эрдэмтэн, оюутан' гэх мэт. Зарим үед хамт олны санаа нь алдагдаж нэгж ухагдахууныг

илтгэсэн ч байдаг. Жишээ нь: ‘амьтан, мэргэжилтэн’ гэх мэт [Орчин цагийн монгол хэл 1966: 78] гэснийг цаашдын судлаачид улам дэлгэрүүлэн судалсан байна.

А. Нэр томьёонд уг дагаврын бүтээлч үүрэг нь байгалийн шинжлэх ухаанд амьтан ургамлын ангилал зүйн дотор багийн нэрийг бий болгохдоо *-тан*⁴ дагавраар хэлбэржүүлж, нэр томьёо бүтээсэн нь өдгөө хэрэглэгдэж байна. Энэ нь хам олны утгыг нэр томьёонд өргөжүүлэн хэрэглэсэн хэрэг юм.

«Монгол орны шувууны зүйлийн нэрний арван хэлний толь бичиг»-т Боршувуутан, Галуутан, Гахуунтан, Налтан, Өвөөлжтөн, Өрвитөн, Тагтаатан, Тахиатан, Тоншуултан, Тогоруутан, Ураацайтан, Уультан, Халуутан, Хиазтан, Хөхөөтөн Шонхортон гэж 16 багийн нэрэнд уг дагаврыг хэрэглэсэн байдаг нь угтаа монгол оронд 16 багийн шувуу байгааг зааж буй хэрэг юм [Болд, Цэвээнмядаг, Болдбаатар, Майнжаргал 2007: 160].

Энэ мэтээр амьтны нэр толь бичигт хэрхэн тэмдэглэсэн талаар лавлан үзвэл «Дэлэнтний ангилал зүй ангилбарын монгол нэр томьёо»-нд (2003) Шавж идэштэн (Шавжичтан), Далавчтан, Туулайтан, Мэрэгчтэн, Мэрүүртэн, Мах идэштэн (Махчтан), Туурайтан, Саарьтан, Туруутан гэж монгол орны хөхтөн амьтны 9 багийг толиндоо оруулсан байна. Тухайлбал,

Битүү тууртан ‘непарнокопытные’ (1)
Луулийн язгууртан ‘маревое семейство’ (1)

Шоргоолж идэштэн ‘муравьеды’ (1) гэх мэт.

Энэ толинд ‘махачтан, шавжитчан’ [Дэлэнтний ангилал зүй 2003: 21] гэсэн нэр томьёо байх бөгөөд түүний дагаврын хийсвэр утга махаар хооллодог, махчин амьтан гэсэн утга илтгэж байхад «-ин»-ийг хасч, дээр нь *-тан*⁴ дагавар залгаснаар хоёр үгийг хураасан шинжтэй боловч хэлэхэд хэцүү нэр томьёо үүсчээ.

Б. Байгалийн шинжлэх ухаанд багийн нэр үүсгэхээс гадна тухайн шинж чанар бүхий амьтан ургамлыг нэрлэсэн үүргээр *-тан*⁴ дагавар мөн хэрэглэгдэж байна.

Олон салаа гэдэстэн ‘турбеллярий многоветвистокишечный’ (2)

Эгнээ шүдтэн ‘рядозубые’ (2)

Хүн дүртэн ‘человекообразные’ (2)

Ясархуу биетэн ‘костистые’ (2) гэсэн жишээнээс харвал эдгээр нь багийн нэрийг заасан хэрэг биш. Тухайн нэг зүйл амьтны шинжийг илтгэн нэрлэсэн хэрэг юм.

В. Гол төлөв эрдэс, чулуулгийн нэр томьёонд *-тан*⁴ дагавартай нэр томьёо бидний Textstat программаар тооцоолсноор «Орос монгол нэр томьёоны толь» гурван ботид 98 удаа тохиолдоно [ОМНТТ 1964, 1970, 1979]. Утгаараа тухайн эрдэс дангаараа биш холимог гэдгийг илтгэж «хольцтон» хэмээх үгээр нэр томьёо бүтээжээ. Ингэхдээ нэр эрдсийн хольцтой бол

Хүхрийн хольцтон ‘колчедан серный’ (2)

Алтан хольцтон ‘колчедан золотоносный’ (2)

Дицийн хольцтон ‘колчедан мышьяковый’ (2) гэсэн нэр томьёо бүтээснээс гадна нэгээс илүү хольцтой эрдсийг

Албинт хүнцлийн хольцтон ‘колчедан кобальтомышьяковый’ (3)

Төмөрмөнгөний хольцтон ‘аргиропирит’ (3)

Албинт хүнцлийн хольцтон ‘колчедан кобальтомышьяковистый’ (3) зэргээр хэрэглэж байна.

*-нцар*⁴ дагавар

Уг дагаврын утгын талаар анхны бүрэн хэлзүй болох «Орчин цагийн монгол хэл» (1966) хэмээх бүтээлд *-нцар*⁴ дагавар нэрийн үндсэнд залгаж хүний садан төрлийг заан үзүүлсэн утга бүхий жинхэнэ нэрийг үүсгэнэ. Жишээ нь: ‘зээнцэр, гучинцар’ гэх мэт. Мөн холбогдох нэрийг багасгасан утга бүхий жинхэнэ нэр үүсгэнэ. Жишээ нь: ‘атанцар, уутанцар’ гэх мэт. Мөн уул үгийн үндсэн шинж чанар, төрх байдлын адил төсөөтэйн санааг илтгэсэн жинхэнэ нэр үүсгэнэ. Жишээ нь: ‘зууванцар, шилэнцэр’ гэх мэт. Бас уг зүйлд идэвх дуртайн санааг илтгэсэн жинхэнэ нэр үүсгэнэ. Жишээ нь: ‘архинцар, маханцар’ гэх мэт [Орчин цагийн монгол хэл 1966: 79] гэсэн бол дагаврыг тусгайлан судалсан эрдэмтэн Л. Болд *-нцар*² дагаврыг «Энэ дагавар нь төрөл садны нэрсийг заасан нэр үүсгэдэг. Жишээ нь: гуч — гучинцар, зээ — зээнцэр. Уул дагавар нь *-гүй* хэлбэрээр орчин цагийн монгол хэлний зарим үгэнд уламжлагдан ирсэн. Жишээ нь: охинцор „охин байдалтай — охин“.

Багасгасан утга илэрхийлнэ. Жишээ нь: уутанцар „жигжиг уут“, чононцор „ерийн чононоос жигжиг чоно“, тэргэнцэр „жигжиг тэрэг“. Уул нэрийн утгатай шинж чанар төрх байдлын адил төсөөтэйн санааг илтгэсэн үг үүсгэнэ. Жишээ нь: болронцор „хэлбэр янз бүр талст бүхий, болрын нэг зүйл“,

зууванцар „зууvand төсөөтэй — зууван“.

Уг зүйлд дуртай, идэвхтэй санааг илтгэнэ. Хоолонцор „хоол идэхдээ ховдог“. Энэ дагаврын *-цар*⁴ хувилбарыг „*-н*“ ээр төгссөн үгэнд (охин+цор=охинцор), *-нцар*⁴ хувилбарыг „*-н*“ ээс бусад төгсгөлтэй үгэнд залгана. Гэхдээ уул үг эгшгээр төгссөн бол уул дагаврыг шууд (зээ+нцэр=зээнцэр) гээд орчин цагийн монгол утга зохиолын хэлэнд төдий л идэвхтэй хэрэглэгдэн шинэ үг үүсгэн үгийн санг баяжуулдаггүй» [Болд 1986: 93] хэмээжээ.

Эрдэмтэн Т. А. Бертагаев «Энэ дагавар үгийн бүтцэд орохдоо бүрэн бус сул гэсэн утга бүхий чанар заасан тэмдэг нэр бүтээдэг. Тухайлбал, харанцар, ихэнцэр, мөн „хүн“ гэдэг язгуурт залгаж бүрэн бус хүн, хүнэрхүү гэсэн утгатай үг үүсгэдэг. <...> Мөн ураг төрлийн нэрэнд залуу үеийг нэрлэхдээ зээнцэр, мөн тухайн зүйлтэй адил төстэй гэсэн утгатай хүүхэнцэр, чононцор, үхээнцэр гэх мэт үг, жижигрүүлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ» [Бертагаев 1974: 196] гэжээ.

«Орчин цагийн монгол хэл» бүтээлд «Нэр үгийн язгуурт залгаж, тухайн юмны шинж бүрэн гүйцэд биш боловч голлосон утга бүхий нэр үг үүсгэнэ. Жишээ нь: зээ — зээнцэр, мөөг — мөөгөнцөр, манан — мананцар гэх мэт. Мөн тухайн нэрээр илэрч буй юманд шунаг шинжтэйг илтгэсэн нэр үг бүтээнэ. Жишээ нь: ам — аманцар ..., хээ — хээнцэр гэх мэт» [Орчин цагийн монгол хэл 1997: 172].

«Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал» (2014) бүтээлд

— Хүний эшийн нэр. Жишээ нь: ачинцар, ... үенцэр гэх мэт.

— Адил төстэй утга. Жишээ нь: савханцар, хуванцар, мөөгөнцөр, мананцар, тоосонцор гэх мэт.

— Багасгасан утга. Жишээ нь: хэлэнцэр, навчинцар, уутанцар, тэргэнцэр, чононцор гэх мэт.

— Үл ойшоох, егөөдөн ёгтолсон баймж утга. Жишээ нь: даргацнар, буханцар, бөхөнцөр гэх мэт.

— Дур идэвх, шунаг шинжийн утга. Жишээ нь: үгэнцэр, хээнцэр, хоолонцор, аманцар гэх мэт [Мөнх-Амгалан, Кан Шин 2014: 28]

Бид хамгийн олон нэр томьёотой «Орос-монгол нэр томьёоны толь»-ийн хоёрдугаар ботийн *-нцар*⁴ дагавартай нэр томьёог TextStat программаар тооцоолоход давхардсан тоогоор 218 нэр томьёо байв.

А. Байгалийн ухааны нэр томьёонд нэрийн үндсэнд *-нцар*⁴ дагаврыг залгаж тухайн юмыг багасгасан утга бүхий үг бүтээдэг байна. Жишээлбэл, үндсэнцэр ‘корешки’ [УНТКМ 1962: 6], навчинцар ‘листочки’ (7), үрэнцэр ‘семянка’ (12) гэж ургамлын нэр томьёонд хэрэглэдэг бол, хулганацар ‘хээрийн хулганацар’ (19), алтайн хулганацар ‘мышевка алтайская’, тэнгэр уулын хулганацар ‘мышевка тьяншаньская’ гэж амьтны нэр томьёонд Нулимсны уутанцар ‘слёзный мешок’ (2) гэхчлэн энэ утгаар үүсгэсэн нэр томьёо харьцангуй олон байна.

Эрдэс чулуулгийн нэр томьёонд жижиг талстуудыг нэрлэж, Бадмаарган гялтганцар ‘рубиновая слюдка’ (2), Зэсийн гялтганцар ‘медная слюдка’ (2), Нүүрст болронцор ‘кварцит углистый’ (2), Цэнхэр болронцор ‘кварцит голубой’ (2) зэрэг нэр томьёо бүтээжээ.

Б. Уг дагавар бүхий нэр томьёо нь тухайн юмтай адил төсөөтэй утга илтгэж нэр томьёоны үүргээр байгалийн ухааны салбарт хэрэгдэгдэнэ. Бараан мананцар ‘темные туманности’ (2), Гаригархуу мананцар ‘планетарные туманности’ (3), манинцар ‘гермафродитизм’ (3), Болронцор чулуу ‘кварцит’ (2), Албинцар ‘кобальтин (кобальтит)’ (2), Бөөлжүүлэх чулуунцар ‘рвотный камень’ (2), Москвагийн лийрэнцэр алим ‘грушовка московская’ (2), манан, болор, чулуу, лийр, манин шинжтэй төстэй учир эдгээр нэр томьёо үүссэн байна.

Мөн мөөг язгуурт *-нцөр* дагавар залгаж мөөгөнцөр ‘микоз’ (2) хэмээн нэг төрлийн нян болон энэ нянгаар үүссэн өвчний нэр томьёо бүтээжээ.

Бичил амь судлалын нэр томьёонд *-нцар*⁴ дагаврын тусламжтайгаар цоо шинэ нэр томьёо бүтээсэн байна. Жишээ нь, Гэдэсний иж савханцар ‘паракишечная палочка’ (3), Балнадын савханцар ‘тифозная палочка’ (2), Сүрьеэгийн савханцар ‘палочка туберкулёзная’ (3) гэсэн нэр томьёоны савханцар нь савх язгуурт *-нцар* дагавар залгаж бүтсэн үүсмэл нэр томьёо юм. Савх нь хоёр нарийн урт яс буюу хулс зэргээр хийж хоол хавчин этэж идэх хэрэгсэл [Цэвэл 1966: 458] хоолны хэрэгсэл бөгөөд түүний нарийн урт шинжийг тусган *-нцар*⁴ (багасгах утгатай) дагавар залган ийм хэлбэртэй олон зүйл нянгийн нэрлэлт буюу нэр томьёо бүтээсэн нь «Орос-монгол нэр томьёоны толь» 3 ботид 54 удаа янз бүрийн нийлмэл нэр томьёоны бүрэлдэхүүнд багтаж шинэ нэрлэлт үүсгэжээ.

В. Мөн олон бүрдэл хэсэгтэй эд эрхтний нэгэн хэсгийг нэрлэсэн нэр томьёо бүтээсэн байна. Тухайлбал, Элэгний хэлтэнцэр ‘долька печеночная’ (2), Уушигны хэлтэнцэр ‘легочные дольки’ (2), Уушигны хэлтэнцэрийн үрэвсэл ‘воспаление легких, лобулярная пневмония’ (2) гэх мэтээр элэг уушгитай холбоотой нэр томьёонд хэрэглэж байна.

Эрдэмтэн О. Адьяа *-нцар*⁴, *-цар*⁴ дагавраар бүтсэн нэр томьёо нь ангаахын болон газар зүйн салбарт тугалганцар (бабит), цахиранцар (кремнезем), савханцар (палочка), мөөгөнцөр (грибки) гэх мэт. Эдгээр нэр томьёо нь зөвхөн багасгасан утгаас гадна доромж утга илтгэнэ. Ер нь орос монгол хэлнээ өчүүхэн, бяцхан, өчүүхэн, бичил гэсэн утга илтгэнэ [Адьяа 2011: 101] гэх буюу эрдэмтэн Т. А. Бертагаев уг дагавраар багасгасан утгатай нэр томьёо бүтээхээс гадна үүссэн нэр томьёо нь тухайн зүйлийн бүрэн бус шинжтэйг илтгэнэ [Бертагаев 1974: 195] гэсэн нь бидний авсан жишээтэй тохирч буй юм.

*-гана*⁴ дагавар

Энэ дагаврын утгын талаар Л. Болд «Энэ дагавраар ургамал, амьтны нэрийг заасан нэр үг үүсгэнэ. Жишээ нь: алтгана, харгана. Мөн бүтсэн ургамал, амьтны нэрийг авч үзвэл бас багассан утга илэрхийлдэг. Жишээ нь: хэдгэнэ — амьтан, зөгийн аймгийн нэгэн зүйл ялаа, батгана — амьтан нэгэн зүйлийн ялаа, улаалзгана — ургамал, бөөрөнхий улаан жимсгэнэтэй сөөг ургамал, гичгэнэ — ишгүй, газраар наалдан ургадаг олон наст ургамал гэжээ [Болд 1986: 92].

«Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал» бүтээлд уг дагаврын утгыг:

— Тухайн нэрийн дагуух ургамлын зүйлийн утга. Жишээ нь: харгана, алтгана, жимсгэнэ, зээргэнэ, хадаасгана, азаргана, улаагана, чөдөргөнө гэх мэт.

— Мөн идэвхгүй язгуураас энэ дагавраар үүссэн зэтгэнэ, зээргэнэ, гичгэнэ, хэдгэнэ, батгана, хулгана, долоогоно гэх мэт үгс буй [Чоймаа 1997: 170]. Тэрчлэн алтаргана, агширгана, балчиргана, зажилгана (хонин зажилгана), чацаргана гэх мэт ургамлын нэрийг ч үүнд хамааруулж болох юм [Мөнх-Амгалан, Кан Шин 2014: 32] хэмээн ойролцоо утгаар тодорхойлжээ.

А. Уг дагаврын үндсэн шинж нь нэр язгуур үндсэнд залгаж тухайн юмын дагуу нэр үг бүтээдэг онцлогтой. Энэ шинж дараах нэр томьёонд уламжлагдан ирсэн байна.

Улаагана ‘смородина красная лесная’ (3), Хонхорт харгана ‘чингиль серебристый’ (3), Тэмээн харгана ‘янтас’ (1), Алтгана ‘строение (стриж желтый)’ (3) гэж тухайн ургамал, загасны нэрэнд улаан, хар, алт гэсэн өнгө заасан тэмдэг нэрийн шинжийг тодотгож *-гана*⁴ дагавартай нэр томьёо болжээ.

Харин Зээргэнэ (өвс) (3) ‘трава «эфедры»’ хэмээх нэр томьёог энэ ангилалд хамаарна хэмээн үзэхийн учир уг ургамал тод ногоон биш, хул шаргал өнгөтэй тул язгуур нь «зээрд» байсан байж болох юм. Хэлэхийн явцад «зээрд»-ийн *-д* гээгдэж «зээргэнэ»-тэй амьтан, ургамлын нэр үүссэн байж болох юм.

Морин зээргэнэ, Хошоон ‘донник’ (1), Намгийн зээргэнэ (ург) ‘хвош болотный’ (1),

Халимагт зээргэнэ ‘славка-черно-головка’ (3).

Б. Уг дагавраар амьтан ургамлын хэлбэр дүрсийг заан нэрлэсэн утгатай нэр томьёо бүтээжээ. Жишээлбэл: бутарсан, сархиатсан, гялтганасан шинжтэй ургамал, чулууг нэрлэх нь түгээмэл байна.

Бударгана ‘солянка’ (1), Өргөст бударгана (өргөст хамхуул) ‘солянка сборная мясная’ (2), Сархитгана ‘полевка обыкновенная (серая)’ (2), Лобелийн агширгана, цагаан агширгана ‘чемерица лобеля’ (2), Гялгана (загас) ‘чебак’ (1), Гялгана (чулуу) ‘авгит’ (1) зэрэг нэр томьёо нь «Орос-монгол нэр томьёоны толь»-ийн I ботид «бударгана» давтагдсан тоогоор 18 удаа тохиолдох бөгөөд гарал нь «бут+р» хэмээх дүрслэх язгуураас үүсэлтэй.

Амьтны дуугарах дуу авиаг дууриан «цүүр цүүр хийх», «хэд хэд хийх» гэсэн язгуурт *-гэнэ* залгаж үүссэн Цүүргэнэ ‘саранча’ (3), Хэдгэнэ ‘шмели’ (3) гэдгээс өөр нэр томьёо тааралдсангүй.

В. Уг дагаврыг нэр үгэнд залгаж тухайн зүйлтэй төсөөтэй гэсэн утгатай нэр томьёо бүтээсэн байдаг. Тухайлбал: Буурцгана (шар буурцаг) ‘соя’ (1), Сүүгэнэ ‘молочай’ (1), Салаагана ‘хориспора’ (2) 5 удаа, Гичгэнэ ‘лапчатка гусиная’ (1), Шүүдэргэнэ (өвс) ‘трава «чистотел»’ (3), Жимсгэнэ ‘ягода’ (1), Жимс, жимсгэний дарс ‘вино’ (1), Бөөрөлзгөнийн жимсгэнэ ‘ягоды малины’ (3) зэргийн буурцаганд буурцагт ургамлын шинж, сүүгэнэд сүүтэй юм шиг цагаан шүүс, жимсгэнэд жимсний шинж цөм бий.

Г. Ургамал, загасны нэрэнд харь гаралтай үгээс үүсэлтэй *-гана*⁴ дагавартай

үгс цөөнгүй байгааг Тавилгана (ургамал) ‘таволга’ (1), Суладай, нагана ‘нагана’ (раст.) (1) зэрэг нэр томьёоноос харж болох агаад монгол үг биш шууд хуулбарлан монгол мэт болгосон нэр байна. Мөн Адгана согос ‘чебак амурский’ (3), Явган тургана ‘шелковица белая’ (3), Ялам (мод), тургана ‘шелковица’ (3) зэрэг загас болоод модны нэр ч гарлын хувьд өөр хэлнийх бөгөөд цаашид судлан үзүүштэй.

Уг дагаврын монгол хэлний үгийн санд үг бүтээх чадамж нь нэр томьёог бодвол харьцангуй идэвхгүй шинжтэй. Нэр томьёонд идэвхтэй хэдий ч үгийн бүтцийг зөрчин идэвхгүй язгуур, үйл язгуурт *-гана*⁴ дагаврыг залгаж бүтээсэн нэр томьёо байгааг дурдвал, Зэржигэнэ ‘славка’ (3), Тарчигнаа зэржигэнэ ‘славка-завирушка’ (3), Булаагана, булаана ‘смородина темнопурпурная’ (3), Япон наймалтгана ‘фатсия японская’ (3), Ноорсгоно ‘пухонос дернистый’, Шигүү ноорсгоно ‘пухон’ зэрэг болно.

Бид судалгаандаа 120000 орчим нэр томьёог багтаасан «Орос-монгол нэр томьёоны толь» гурван боть толийг хэрэглэгдэхүүн болгож, улмаар TextStat программаар тооцоолон судалгаа хийхэд *-гана*⁴ дагавраар бүтсэн нэр томьёо давхардсан тоогоор 68 удаа тохиолдов.

*-лан*⁴ дагавар

«Орчин цагийн монгол хэл» бүтээлд *-лан*⁴ дагаврыг нэрийн үндсэнд залгавал малын нас шүдийг заасан жинхэнэ нэр үүсгэнэ. Жишээ нь: хязаалан, шүдлэн, соёолон гэх мэт. Мөн хийсвэр утга бүхий жинхэнэ нэрийг үүсгэж болно. Жишээ нь: Тариалан, хүрээлэн, дугуйлан гэх мэт [Орчин цагийн монгол хэл 1966: 80].

«Орчин цагийн монгол хэлний дагавар» бүтээлд уг дагаврыг Тухайн үйлийн үр дүнг, мөн уг үйлийн болох орон заасан үг үүсгэдэг. Жишээ нь: цатгалан, өлсгөлөн.

*-лан*⁴ дагаврыг нэр үгийн ард залгаж малын нас, шүд заасан нэр мөн хийсвэр утгатай нэр үг бүтээдэг боловч тийм биш соёол, хүрээл мэтийн үйл үгийн үндсэнд *-н* дагавар залгаж тухайн үйлийн үр дүнг заасан нэр үг үүсгэжээ. Жишээ нь: шүдэл — шүдлэн, дугуйл — дугуйлан, хүрээ — хүрээлэн.

Тухайн үйлийн үр дүнг заасан хийсвэр нэр, мөн бэлэг тэмдгийг заасан нэр үүсгэнэ. Жишээ нь: баясгалан, жаргалан, амгалан, жавхлан.

Тухайн үйлийн болох байрыг заана. Жишээ нь: зуслан.

Үйлийн явц байдал, үр дүнг харуулсан нэр үг үүсгэнэ. Жишээ нь: исгэлэн, өсгөлөн, цатгалан.

Үйлд өртөх зүйлийг заана. Жишээ нь: хадлан, орчлон [Болд 1986].

«Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал» бүтээлд уг дагаврын утгыг

- Үйлийн дагуух шинж, төлөв байдал заасан утга. Жишээ нь: амгалан, жаргалан, сэргэлэн, баясгалан, хүслэн, өлсгөлөн гэх мэт [Мөнх-Амгалан, Кан Шин 2014: 44].
- Үйлийн орны утга. Жишээ нь: зуслан, хадлан, орчлон гэх мэт гэжээ [Мөнх-Амгалан, Кан Шин 2014: 44].

*-лан*⁴ дагавраар дараах хоёр хэв шинжийн нэр томьёо бүтээнэ.

А. Нэр үгийн үндсэнд залгаж, үр дүнг заасан нэр үг бүтээнэ. Үүнд:

Газар тариалан ‘земледелие’ (1), Капиталист газар тариалан ‘капиталистическое земледелие’ (2), Газар тариалан ба ойн аж ахуй ‘земледелие и лесоводство’ (2), Таваарын газар тариалан ‘товарное земледелие’ (2), Тамхины тариалан ‘табачная плантация’ (2), Газар бодис зүйн хүрээлэн, геофизикийн хүрээлэн ‘геофизический институт’ (1), Хувийн газар тариалан ‘частное земледелие’ (2) гэсэн нэр томьёонд «тариалан» өндөр давтамжтай, Ногоолон ‘малахит’ (1).

Б. Мал, амьтны нас хүйсийн нэрэнд тохиолдоно.

Хуудай (хязаалан) ‘трехлетка’ (1), Шүдлэн азарга ‘жеребец двухлетний’ (2), Соёолон ‘четрыхлетка’.

В. Үйл үгэнд залгаж, түүний шинж төлөвийг заасан нэр томьёо үүсгэнэ.

Исгэлэн хурган чих, жижиг хурган чих (Дааган чих) ‘щавель малый’ (2), Исгэлэн орчин ‘среда кислая’ (2), Исгэлэн ус ‘вода кисловатая’ (2), Гүнзгий эсгэлэн ‘подрез глубокий’ (1).

Г. Үйл язгуурт залгаж үйлийн үр дүнг заасан нэр үг үүсгэнэ.

Хадлан ‘сенокос’ (1), Хадлангийн чичрэг ‘лихорадка жатвенная’ (1).

-ч, -чин дагавар

Л. Болд «Орчин цагийн монгол хэлний дагавар» (1986) бүтээлдээ «Монгол хэлний *-ч* дагавар нь *-чин* дагаврын хувилбар агаад тухайн зүйлийг байнга болон түр эрхэлсэн хүний ажил мэргэжлийг заасан нэр үүсгэнэ. Байнга буюу түр эрхэлсэн мэргэжлийг заасан нэр үг үүсгэдэг. Жишээ нь: хөгжимчин, тариачин, сумч, загасч.

Энэ дагавар угсаатан, ястны нэрийн бүтцэд нилээд оролцдог. Жишээ нь: хорчин „нум агсаж хоромсого зүүгчид“, захчин „анх овог, ястны нэр биш, торгууд зэрэг омгийн хэсэг иргэд харуулын алба гүйцэтгэж захаар нутаглаж явсан учир ингэж нэрлэх болжээ“.

-ч дагавар нь тухайн үйлийг эрхэлдэг, мөн уг зүйлд дур идэвхтэйн санааг илтгэсэн нэр үг үүсгэнэ. Жишээ нь: ажилч.

-ч дагавар нь нийгэм улс төрийн хэллэгт тухайн нэрийн дагуух онол үзлийг баримталсан утга илэрхийлнэ. Жишээ нь: хувьсгалч — хувьсгалын онол ухааныг хэлбэрэлтгүй баримтлан дэлгэрүүлэх ба тэр үйл хэрэгт буцаж няцашгүй зүтгэгч хүн, онолч — онолд мэргэжсэн хүн.

Монголын судлалын ном зохиолоос үзвэл энэ нь биеэ даасан хоёр өөр дагавар биш, нэг дагаварын хоёр хувилбар гэж үздэг. Гэтэл эдгээр дагавар нь нэгийнхээ тохиолдох газар нөгөө нь тохиолдож байгаагийн гадна яг адил утга илэрхийлэхгүй байна. Жишээ нь: ажилч — ажил үйлдвэрт шамдуу хичээнгүй, ажилчин — нийгмийн тодорхой ангийг заасан нэр. Иймээс монгол хэлний үг бүтээх дагаврыг судалсан зарим бүтээлд -чин, -ч дагаврыг биеэ даасан хоёр өөр дагавар болгон оруулж байна. Харин бид энэ удаад уул дагавруудыг нэг дор оруулахдаа уул дагаврыг авч үүссэн үгийн утга ойролцоо байдалд тулгуурлав» [Болд 1986: 14] гэсэн утга нь:

А. Байгалийн ухаан салбарт нэр үгэнд -чи, -чин дагаврыг залгаж ажил мэргэжил заасан нэр үүсгэнэ. Агтач (адуучин) ‘конюх’ (2), Агтчин, адуучин ‘табунщик’ (2), Аж ахуйн эрхлэгч ‘заведующий хозяйством’ (2) гэх мэт.

Харин Ажилчин зөгий ‘пчела рабочая’ (2) хэмээх нэр томьёог хүний ажил хөдөлмөр эрхэлдэг шинжтэй адил үүрэгтэй тул утга шилжүүлэн нэрлэсэн хэрэг юм.

Б. Тухайн амьтныг юунд дуртайгаар нь нэрлэхдээ -ч дагаврыг хэрэглэсэн тохиолдол байна. Жишээбэл: Алимны балч шавьж ‘медведка яблочная’ (2), Алимны хөрвөгч цох ‘жук златка яблочная’ (2), Алимны цэцэгч цох ‘жук цветоед яблочный’ (2), Азийн навчич цох ‘жук листоед азиатский’ (2) зэрэгт баланд, цэцгэнд, навчинд дуртайгаар нь ийнхүү нэрлэжээ.

В. Байгалийн ухааны галавын нэрэнд «гал» хэмээх язгуурт -чин дагавар залгаж «галчин» хэмээх шинэ нэр томьёо бүтээсэн байна. Энэ нь «Орос-монгол нэр томьёоны толь»-ийн нэгдүгээр ботид 20, хоёрдугаар

ботид 20, гуравдугаар ботид 13 давтагдсан тоогоор нийт 53 ийм нэр томьёо байна.

Атриашлын химмерийн галчин үе ‘киммерийская эпоха скаладчатости’ (2)

Мөстлийн дараах галчин үе ‘последниковая эпоха’ (2)

Тектоник өргөгдлийн галчин үе ‘эпоха тектонических поднятий’ (2)

Мөстлийн хожуу галчин үе ‘позднеледниковая эпоха’ (2) гэх мэт.

-ч дагавар нь -чин дагаврын хувилбар шинжтэй бөгөөд нэр томьёонд бүрэнхийч — бүрэнхийн багваахайн төрөл [Дэлэнтний ангилал зүй 2003: 11], үлийч- [Дэлэнтний ангилал зүй 2003:18] Мэхээрч оготно [Дэлэнтний ангилал зүй 2003:19] гэх мэтээр өргөн хэрэглэжээ. -С, -сін дагавар нь байнга буюу түр эрхэлсэн мэргэжлийг заасан нэр үг үүсгэдэг хэмээн тэмдэглээд гол төлөв нэр үгээс нэр үг бүтээх үүрэгтэйг онцолжээ. Дээрх хоёр үгийн үлийч гэдэг нь үлий хийдэг гэсэн утга байдаг бол бүрэнхийч гэхэд бүрэнхий эрхэлдэг гэсэн утга илтгэх тул тохиромжгүй юм.

-ынх⁵, -ынхан⁵

«Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал» бүтээлд уг дагаврын утгыг «хураасан хам олны утгатай. Жишээ нь: ахынхан, шумуулынхан, хануурынхан гэх мэт» [Мөнх-Амгалан, Кан Шин 2014: 32] хэмээн тэмдэглэжээ.

Байгалийн ухааны нэр томьёо түүний дотор ургамал, амьтны нэр томьёонд зүйлийн ангиллыг нарийвчлан баримталж, үүний үрээр нэр томьёо нь дэлхийн ангилалтай дүйцэж явдаг онцлогтой. Энэ ангиллын ангийн нэрийг -ууд² нөхцөлөөр (дэлэнтнүүд), багийн нэрийг -тан⁴ дагавраар (туулайтан), овогийн нэрийг -ынхан, -ынхон, -ийнхэн төгсгөлөөр (зарааныхан) жигдэлж, төрлийг дан үгээр (хүдэр) байхаар жигдэлсэн байна.

А. Хөхтөн судлаач С. Дуламцэрэнгийн боловсруулсан «Дэлэнтний ангилал зүй, ангилбарын монгол нэр томьёо» (2003) бүтээлд овогийн нэрийг -ынхан, -ынхон, -ийнхэн төгсгөлөөр жигдэлж Зарааныхан, Чацуулиныхан, Жөвүүгийнхэн, Багваахайнхан, Огдойнхон, Хэрмийнхэн, Минжийнхэн, Шишгийнхэн, Хулганыхан, Унтаахайнхан, Хулганцарынхан, Алагдааганыхан, Баавгайнхан, Суусрынхан, Адууныхан, Тэмээнийхэн, Гайханхан, Тугайлмайтныхан гэх 18 овгийн нэрийг энэ дагавраар жигдлэн оруулсан байна.

Б. Мөн уг дагавраар нэг бүс нутагт хамаарах амьтан, хүн зэргийг заасан нэр томьёо бүтээнэ. Жишээбэл,

Ёроолынхон ‘бентос; донные животные и растения’ [БАМРС 2001: 140] (1), Азийнхан ‘азиаты’ (1), Суунга ёроолынхон ‘сиенит; магматическая плутоническая горная порода среднего состава’ (3), Уг нутгийнхан ‘туземец’ (2), Уугуул нутгийнхан ‘автохтоны’ (2) гэх мэтээр «Орос-монгол нэр томьёоны толь»-д 11 удаа байх 3 дэвтэрт яг адил нэр томьёог хэвээр авсан байна.

-цаг⁴ дагавар

«Орчин цагийн монгол хэл» (1966) бүтээлд энэ дагаврын талаар дурдаагүй бол эрдэмтэн Л. Болд «-цаг⁴ дагавар авч үүссэн шинэ үг нь багасгасан мөн үл тоомсорлосон утгатай нэр үг байна. Жишээ нь: оронцог — юмыг голон дооршоож өгүүлэх, довцог — ов төв өндөрхөн газар гэхдээ довоос арай жижиг. -цаг⁴ дагаврын тусламжтайгаар үүссэн шинэ үгүүдийг уул анхдагч үндэстэй нь харьцуулан үзвэл багассан биш, өөр утга илэрхийлэх нь олонтаа байна. Жишээ нь: бөмбөрцөг „жижиг бөмбөр гэсэн утга илэрхийлээгүй харин дэлхий, нарт гариг, газар гэсэн утгатай байна“, мөрөгцөг „газрын тохойрсон мөгүү эрэгцэг“» [Болд 1986: 87] гэжээ.

«Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал» (2014) бүтээлд

- Хэлбэр байдлыг багасган адилтгасан утга. Жишээ нь: эрэгцэг, довцог, мөрөгцөг, товцог гэх мэт.
- Юмын шинжийг адилтгасан утга. Жишээ нь: зээрэнцэг, бөөрөнцөг, бөмбөрцөг, хонхорцог, хэнхэрцэг, түнгэрцэг гэх мэт.
- Юмын шинжийг чамлан буруулсан баймж утга. Жишээ нь: оронцог, холимцог, гяланцаг, паланцаг, янгирцаг гэх мэт.
- Мөн идэвхгүй язгуураас үүссэн оорцог, аарцаг, долгомцог, тоорцог, хайрцаг, буурцаг гэх мэт олон үг байх бололтой [Мөнх-Амгалан, Кан Шин 2014: 32].

А. Аливаа юмыг төстэй шинжээр адилтган багасгасан утгатай нэр томьёо бүтээнэ. Жишээ нь:

- Үрийн довцог ‘семенной холмик’ (1)
- Бэрийн довцог ‘бэровские бугры’ (1)
- цетон, цуунцаг ‘ацетон’ (1)
- Довцог, болдруу, товгор ‘бугор’ (1)

Дөрвөн товцог ‘четырёххолмие’ (1)

Шүлтэнцэг, гистони ‘гистони’ (1)

Б. Шинж чанар бууруулж нэр томьёо бүтээсэн нь оновчтой бус байна. Холимцог гэхээр ямар ч хамаагүй юмыг хольсон гэсэн утга илтгэж байна. Тухайлбал: Махтай холимцог ‘винегрет мясной’ (1), Ногооны холимцог ‘винегрет из овощей’ (1) гэх мэт.

В. Мөн багасгасан утга бүхий Бакхардтын хонгорцог бөмт ‘стафилококковое импетиго’ (1), Хонгорцог хөгц ‘кладаспориум’ (1), Хонгорцог хөгц ‘плесень гроздевидная’ (1), Хонгорцог, Сүлжмэл сав ‘корзинка’ (1), Хонхолцог ‘термопсис ланцетолистный’ (1) зэрэг нэр томьёо бүтээсэн нь бий.

-жс, -жин дагавар

«Орчин цагийн монгол хэл»-д (1966) -жс / -жин дагавар нэрийн үндсэнд залгаж малын эм хүйсийг заан үзүүлсэн жинхэнэ нэр үүсгэнэ. Жишээ нь: Гуна — гунж, дөнө — дөнж гэх мэт [Орчин цагийн монгол хэл 1966: 79].

«Орчин цагийн монгол хэл» бүтээлд» (1997) -жин, -жс дагавар нь дунд үеийн монгол хэлэнд голдуу хүний нэр бас овог аймгийн нэрэнд хэрэглэгдэж байсан тусгай нэрийн дагавар, «-жин» нь эм хүйсийг, «-дай» нь эр хүйсийг илтгэж байжээ. Жишээлбэл: Баргужин гэвэл барга аймгийн эмэгтэйг, Баргудай гэвэл барга аймгийн эрэгтэйг заадаг байжээ. Орчин цагийн монгол хэлэнд малын эм хүйс заасан цөөн үгэнд үлдсэн бүтээлч бус дагавар юм. Жишээ нь: гуна — гунжин, дөнө — дөнөжин [Орчин цагийн монгол хэл 1997: 168].

Тус дагавар бол нэрээс үйл үүсгэх -жс дагавар дээр нөхцөл үйлийн «-н» нөхцөл залгаж бүтсэн нийлмэл дагавар бөгөөд голдуу цаг улирлыг заасан нэр үгээс тухайн цаг хугацааны турш гэсэн санааг илтгэх нэр үг бүтээнэ. Жишээ нь: өдөр — өдөржин, шөнө — шөнөжин, өвөл — өвөлжин гэх мэт.

А. -жин дагавраар үгийн сангийн утга болох эм хүйсийг илгэсэн утгаас огт өөр эрдэс чулуулгийн нэр томьёо үүсгэсэн нь өвөрмөц.

Амфиболт харлагжин ‘амфибовое габбро’ (2)

Анарт асмалжин ‘диорит гранатовый’ (2)

Андалузитын эвэржин ‘андалузитовый роговик’ (2)

Молибдений Анзанжин ‘молибдент Анзант’ (2)

Асмалжин порфир 'порфир диоритовый' (2)
 Асмалжин аплит 'аплит диотривый' (2)
 Асмалжин занар 'сланец диоритовый' (2)
 Асмалжин лимбургит 'лимбургит диоритовый' (2)
 Асмалжин, диорит 'диорит' (2)
 Асмалжины латерит 'латерит диоритовый' (2)
 Божин элсэн чулуу 'песчаник аркозовый' (2)
 Божин 'аркоз (аркозовый песчаник)' (2)
 Божин гнейс 'гнейс аркозный' (2)
 Божин хөрзөн 'аркозовый конгломерат' (2)
 Божин элсэн чулуу 'аркозовый песчаник' (2) +3
 Божмог шарилж 'полынь сизая' (2)
 Боржин трахит 'трахит гранитовый' (2)
 Боржин үйрмэг 'дресва гранитная' (2) +16
 Босоожин 'змейка длинная' (2)
 Бөөлжин чулуу 'камень рвотный' (2)
 Бүдүүн мөхлөгт хорголжин гялтага 'блеск грубозернистый свинцовый' (2)
 Ванадий, мөнгөлжин 'ванадий' (2)
 Висмут, ягаанжин 'висмут (биесмит)' (2)
 Гаваржин 'камфорозма' (2)
 Молоржин 'топазолит' (2)
 Ногооворжин, глауконт 'глауконититы' (2)
 Танан чулуу, эржин 'арагонит' (2)
 Тунгалаг шохойжин 'прозрачный кальцит' (2)
 Аранжин эрдэс 'самородный минерал' (3)
 Бөөн аранжин 'самородок' (3) гэх зэргээр «Орос монгол нэр томьёоны толь»-ийн хоёрдугаарт 45 удаа тохиолдож буй нь дагавраар жигдэрүүлэн нэр томьёо тогтоож болохыг харуулсан жишээ юм.

Б. Амьтны эм хүйс заасан утгаар мөн хэрэглэгдэнэ.

Эм оймжин 'кочедыжник женский' (2), Оймжин 'кочедыжник городчатый' (2) гэсэн амьтны нэрээс өөр жишээ тааралдсангүй нь хангалтгүй байна.

В. Ургамлын нэрэнд нэг зүйлд багтах ургамлуудыг хооронд нь ялгахын тулд яргуйжин 'ветреница' (3), ацан яргуйжин 'ветреница вильчатая' (3), сэгсгэр яргуйжин 'ветреница длиноволосая' (3), оройн яргуйжин 'ветреница лесная' (3) гэж оноосон «яргуй» гэдэг язгуурт залгаснаас

өөрөөр тохиолдоогүй юм.

Байгалийн ухааны нэр томьёоны бүрэлдэхүүн дэх *-жин* дагавартай үгийг ажиглавал гол төлөв үүсмэл бус «шохой», «бор», «хоргол» зэрэг язгуурт *-жин* дагавар залгаж бүтээх нь түгээмэл агаад уг дагаврын өмнө зөвхөн тэмдэг нэрийн *-вор* дагавар тохиолдож «ногооворжин» хэмээх нэр томьёо бүтээжээ.

-лж, -лжин дагавар

Уг дагаврыг «Орчин цагийн монгол хэл» (1966) бүтээлд дурдаагүй. Л. Болд «-лжин (-лжи) гэсэн хэлбэртэй бөгөөд зарим ургамал, амьтны нэр үүсгэнэ. Шар — шарилж, бор — боролж, тэмээ — тэмээлж. Хэрэв энэ дагаврыг тооны нэрэнд залгавал хэмжих ухааны зохих дүрсийн нэр заасан тэмдэг нэр үүснэ, гурвалжин, дөрвөлжин. <...> Орчин цагийн монгол хэлэнд энэ дагавар бүтээц багатай хэрэглэгддэг. Энэ дагаврыг авч үүссэн үгийг утгын талаас нь нягтлан дор дурдсан хэсэгт хуваан үзэж болох юм. *-лж* дагаврыг нэрийн үндсэнд залгаж, ургамал амьтны нэр үүсгэнэ. Шарилж — цэцгийн язгуурын нэг төрлийн ургамлын нэр. Гурвалж — усанд ургадаг гурвалжин иштэй нэг зүйл өвс» [Болд 1986: 91].

Ц. Өнөрбаян «-лж (лжин) тоонолж, шарилж, гурвалжин» [Өнөрбаян 2004: 26] гэсэн бол «Орчин цагийн монгол хэл»-д [Орчин цагийн монгол хэл 1997] «Нэрийн язгуурт залгаж, уг нэрийн хэлбэр шинж бүхий амьтан, юмыг заасан нэр үг бүтээнэ. Жишээ нь: улаан — улаалж, бор — боролж, өвөө — өвөөлж».

Ю. Мөнх-Амгалан, Кан Шин нарын «Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал» (2014) бүтээлд:

— Тоо, дүрс заасан юмын утга. Жишээ нь: гурвалж(ин), дөрвөлж(ин), тэвхэлж(ин), тавалж(ин), тоонолж(ин), загалмайлжин, хорголж(ин), хошуулж(ин), сараалж(ин)... гэх мэт.

— Тухайн өнгө зүс, хэлбэр дүрс бүхий амьтны нэрийн утга. Жишээ нь: бүвээлж, бүвээлжин, өвөөлж, өвөөлжин.

— Тухайн өнгө зүс, хэлбэр бүхий ургамлын нэрийн утга. Жишээ нь: улаалж, шаралж, боролж, хургалж гэх мэт [Мөнх-Амгалан, Кан Шин 2014: 30].

А. Хэлбэр дүрсээр нь нэрлэж нэр томьёо бүтээсэн

Тоонолжин цэцэгтэн 'крестоцветные' (2)

Сааралжин навчин цэцэг ‘марьянник дубровый (иван-да-марья)’ (2)

Ойн хөвхөлжин ‘лемминг лесной’ (1)

Хорголжин гялтгана ‘галенит (свинцовый блеск)’ (1)

Хорголжин хонд ‘свинцовый сурик’ (1)

Хорголжит урвалж цаас ‘бумага реактивная свинцовая’ (1)

Хорголжны давс (плумбат) ‘плумбаты’ (1)

Шоргоолжин хатиг ‘фурункулез’ (2)

Тэмээлжин хяруул ‘строкофил’ (3) гэх мэт.

Б. Тооны нэрэнд *-лжин* дагавар залгаж бүтээсэн

Шоо дөрвөлжин ‘кубовидный’ (2)

Гурвалжин бөөм ‘ядро треугольное’ (2)

Гарляндын гурвалжин ‘треугольник Гарлянды’ (3)

Зургаалжин ‘гексаго’ (2)

В. Өнгөөр нь нэрлэж нэр томьёо үүсгэсэн

Алтайн шарилж ‘полынь алтайская’ (2)

Ямаан шарилж ‘полынь метёлчатая’ (2)

Цагаалжин аврага загас ‘акула голубая’ (2)

Шөвгөр улаалж ‘белоус торчащий’ (2) гэх мэтээр «Орос-монгол нэр томьёоны толь»-ийн хоёрдугаар дэвтэрт [ОМНТТ 1970] ээрэм, цагаан, царвант, хар хожуу, хонин, үхэр зэрэг тодотголтой шарилж 76 удаа тохиолдоно.

Галт хэмхдэст асмалжин ‘диорит порокластический’ (2)

Мөнгөлж, Мөнгөлжин, аргиназ ‘аргиназа’ (1)

Стронцгийн эржин ‘стронциевый арагонит’ (2) (моссотит)

Суурилаг асмалжин ‘диорит основной’ (2)

*-лзай*³ дагавар

Энэ дагаврын талаар орчин цагийн монгол болон бусад тусгайлан судалсан бүтээлүүдэд түүний утга, гарал зэргийг дурдаагүйгээс харвал үгийн санд төдийлөн идэвхтэй дагавар биш бололтой.

А. Өнгө зүс заасан бор, цагаан, ногоон, ягаан зэрэг тэмдэг нэрэнд уг *-лзай* дагаврыг залгаж тухайн өнгөтэй амьтан, ургамлын нэр томьёо үүсгэнэ.

Цагаалзай ‘нивяник, поповник’ (2)

Үүлэн боролзой болжмор ‘жаворонок полевой’ (2)

Царгиа шар ногоолзой ‘зеленчук’ (2)

Ногоолзой ‘чиж’ (3)

Дагуур цагаалзай хи лим ‘калуга дальневосточная’ (2)

Ягаалзай ‘брайя’ (2)

Боролзой нарсан өвс, зур өвс ‘пижма сибирская’ (1) гэж өвсийг нэрлэсэн бол Боролзой хайлгана ‘альбатрос дымчатый’ (2) гэж нэг зүйл цахлай шувууг «боролзой» хэмээх адил үгээр оноосон агаад шувуу болон өвсний өнгө нь төсөөтэй тул ийм нэр томьёо үүсчээ.

Б. Тухайн амьтан хэлбэр дүрсийн хувьд төстэй амьтныг тухайн нэрэнд нь *-лзай*³ дагавар залгаж нэр томьёо бүтээжээ. Шоргоолзтой төстэй амьтныг шоргоолзтой, могойтой төстэй шувууг моголзой гэж нэрлэх жишээтэй.

Шоргоолзтой тоншоохой ‘вертиголовка (или вертишейка)’ (2)

Моголзой шувуу ‘анхинга’ (2)

Балайлзай гуят царцаа ‘кобылка бахчевая’ (2)

Мөн уг дагавраар нэр томьёо бүтээсэн жишээнээс харвал үгийн язгуур нь тодорхой бус Нүцгэн үрт Шадалзай ‘рохелия голоплодная’ (3), Түмэлзэй чавга ‘спаржа клубеньковая (Спаржа кохинхинская)’ (3) зэрэг нэр томьёо байна.

«Орос-монгол нэр томьёоны толь» гурван ботид давхардсан тоогоор нийтдээ 27 удаа *-лзай*³ бүхий үг тохиолдоно. Түүний дотор цагаалзай гэдэгтэй нэр томьёо 7 удаа тохиолдоно.

Бидний судлан үзсэн эдгээр дагавар нь нэр томьёо бүтээхдээ үгийн сангийн утгын талаасаа өргөжсөн *-ийнхан*, мөн нэг л утгаар хэрэглэгдэх *-гана*, нэр томьёоны тусгай үүрэгтэй *-тан* болсон бөгөөд нэр томьёоны давтамжийг тодорхойлсноор хэрэглээний хүрээг тодруулан цаашид нэр томьёо зохиоход хэрэглэх боломжтой.

ЛИТЕРАТУРА / REFERENCES

Адьяа 2011 — Адьяа О. Сопоставительное терминоведение. Улаанбаатар: Бемби сан, 2011. 173 х. [Adyaa O. *Sopostavitel'noe terminovedenie* [Comparative terminology]. Ulaanbaatar: Bembi San, 2011. 173 p. (In Rus. and Mong.)]

БАМРС II 2001 — Большой академический монгольско-русский словарь / отв. ред. Г. Ц. Пюрбеев. Т. 2. Д-О. М.: Academia, 2001. 536 с. [*Bol'shoy akademicheskii mongol'sko-russkii slovar*] [Great Academic Mongolian-Russian Dictionary]. G. Ts. Pyurbeyev (ed.). Vol. 2. Д-О. Moscow: Academia, 2001. 536 p. (In Mong. and Rus.)]

- Бертагаев 1964 — *Бертагаев Т. А.* Синтаксис современного монгольского языка в сравнительном освещении: Простое предложение. М.: Наука, 1964. 280 с. [Bertagaev T. A. *Sintaksis sovremennogo mongol'skogo yazyka v sravnitel'nom osveschenii: Prostoe predlozhenie* [Modern Mongolian syntax in a comparative perspective: the simple sentence]. Moscow: Nauka, 1964. 280 p. (In Rus.)]
- Бертагаев 1974 — *Бертагаев Т. А.* Лексика современных монгольских литературных языков. М.: Наука, 1974. 382 с. [Bertagaev T. A. *Leksika sovremennykh mongol'skikh literaturnykh yazykov* [Literary vocabulary of contemporary Mongolic languages]. Moscow: Nauka, 1974. 382 p. (In Rus.)]
- Болд, Цэвээнмядаг, Болдбаатар, Майнжаргал 2007 — *Болд А., Цэвээнмядаг Н., Болдбаатар Ш., Майнжаргал Г.* Монгол орны шувууны зүйлийн нэрийн арван хэлний толь бичиг. Улсын нэр томьёоны бичиг. № 2 (150), Улаанбаатар: УХУ, 2007. 180 х. [Bold A., Tseveenmyadag N., Boldbaatar Sh., Maynzharгал G. *Mongol orny shuvuuny züilyin neriyn arvan khelniy tol' bichig* [A ten-language dictionary: names of birds]. *Ulsyn ner tom'eony bichig* (National terminology papers). No. 2 (150). Ulaanbaatar: UKhY, 2007. 180 p. (In Mong.)]
- Болд 1986 — *Болд Л.* Орчин цагийн монгол хэлний дагавар. Улаанбаатар: УХУ, 1986. 132 х. [Bold L. *Orchin tsagiyn mongol khelniy dagavar* [Modern Mongolian: word-forming affixes]. Ulaanbaatar: UKhY, 1986. 132 p. (In Mong.)]
- Дэлэнтний ангилал зүй 2003 — Дэлэнтний ангилал зүй, ангилбарын монгол нэр томьёо. Боловсруулсан С. Дуламцэрэн // Улсын нэр томьёоны комиссын мэдээ. № 148. Улаанбаатар: УХУ, 2003. 72 х. [Delentniy angilal зүү, angilbaryn mongol ner tom'eo. *Bolovsruulsan S. Dulamtseren* [Mongolian mammal classification terminology]. *Ulsyn ner tom'eony komissyn medee* (Bulletin of the State Terminological Commission). No. 148. Ulaanbaatar: UKhY, 2003. 72 p. (In Mong.)]
- Мөнх-Амгалан, Кан Шин 2014 — *Мөнх-Амгалан Ю., Кан Шин.* Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал. II боть. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2014. 382 х. [Mönkh-Amgалан YU., Kan Shin. *Orchin tsagiyn mongol khelniy byteever sudlal* [Modern Mongolian morphology]. Vol. 2. Ulaanbaatar: Soembo Printing, 2014. 382 p. (In Mong.)]
- ОМНТТ 1964 — Орос-монгол нэр томьёоны толь. I боть. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1964. 560 х. [*Oros-mongol ner tom'eony tol'* [Russian-Mongolian terminological dictionary]. Vol. 1. Ulaanbaatar: State Publ. House, 1964. 560 p. (In Rus. and Mong.)]
- ОМНТТ 1970 — Орос-монгол нэр томьёоны толь. II боть. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1970. 1106 х. [*Oros-mongol ner tom'eony tol'* [Russian-Mongolian terminological dictionary]. Vol. 2. Ulaanbaatar: State Publ. House, 1970. 1106 p. (In Rus. and Mong.)]
- ОМНТТ 1979 — Орос-монгол нэр томьёоны толь. III боть. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1979. 740 х. [*Oros-mongol ner tom'eony tol'* [Russian-Mongolian terminological dictionary]. Vol. 3. Ulaanbaatar: State Publ. House, 1979. 740 p. (In Rus. and Mong.)]
- Орчин цагийн монгол хэл 1966 — Орчин цагийн монгол хэл. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1966. 336 х. [*Orchin tsagiyn mongol khel* [Modern Mongolian]. Ulaanbaatar: State Publ. House, 1966. 336 p. (In Mong.)]
- Орчин цагийн монгол хэл 1997 — Орчин цагийн монгол хэл. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1997. 440 х. [*Orchin tsagiyn mongol khel* [Modern Mongolian]. Ulaanbaatar: State Publ. House, 1997. 440 p. (In Mong.)]
- Өнөрбаян 2004 — *Өнөрбаян Ц.* Орчин цагийн монгол хэлний үг зүй. Улаанбаатар: УХУ, 2004. 235 х. [Önörbayan Ts. *Orchin tsagiyn mongol khelniy üg зүү* [Modern Mongolian morphology]. Ulaanbaatar: UKhY, 2004. 235 p. (In Mong.)]
- УНТКМ 1962 — Улсын нэр томьёоны комиссын мэдээ. № 50. Улаанбаатар: ШУАХ, 1962. Ургамлын зарим нэр томьёо. 15 х. [*Ulsyn ner tom'eony komissyn medee* (Bulletin of the State Terminological Commission). No. 50. Ulaanbaatar: ShUAKh, 1962. *Urgamlyn zarim ner tom'eo* [Some plant denoting terms]. 15 p. (In Mong.)]
- Цэвэл 1966 — *Цэвэл Я.* Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966. 913 с. [Tsevel Ya. *Mongol khelniy товч тайлбар tol'* [A concise dictionary of Mongolian]. Ulaanbaatar: State Publ. House, 1966. 913 p. (In Mong.)]
- Чоймаа 1997 — *Чоймаа Ш. нар.* Орчин цагийн монгол хэл. (Их дээд сургуулийн оюутан, багш нарт зориулав). Үг бүтэх ёс. Улаанбаатар: МУИС-ын хэвлэх. 214 х. [Choymaa Sh. et al. *Orchin tsagiyn mongol khel. (Ikh deed surguuliyn oyuutan, bagsh nart zoriulav). Üg бүтэх es* [Modern Mongolian (a study book for university students and lecturers). Word-formation rules]. Ulaanbaatar: National University of Mongolia, 1997. 214 p. (In Mong.)].

Some Mongolian Term-Forming Suffixes: Frequency of Use and Application

*Gerelma Guruuchin*¹

¹ Ph.D. in Philology, Professor, Head of Department of Applied Linguistics, Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences (54A, Zhukov Avenue, Ulaanbaatar, 13330, Mongolia).
ORCID: 0000-0001-53160233. E-mail: g_mgl2003@yahoo.com

Abstract

The article calculates the meanings and frequency use of some Mongolian term-forming suffixes by the aid of TextStat program.

The present paper deals with meanings, functions, frequency and application of some Mongolian term-forming suffixes, such as *-тан*⁴, *-нцар*², *-гана*⁴, *-лзай*³, *-ж*, *-жин*, *-ч*, *-чин*, *-ийнхан*². The study examines terms to denote plants, animals, minerals and geological objects related to natural sciences in the Russian-Mongolian Terminological Dictionary (editions of 1964, 1970, and 1979) containing 120,000 terms.

The study includes two main sections. Firstly, it summarizes works by scientists to have studied the meanings of the suffixes mentioned above, and examines which of the meanings are more frequently used to create terms. Among the scientists who have investigated the Mongolian suffix *-тан*, T. A. Bertagaev described its meaning as follows: 1. 'massive', e.g., *цэргийн эрхтэн* 'military authorities, militarists'; 2. 'singular / plural', e.g., *цагаантан* 'white guardsman, white guardsmen'; 3. 'singularity', e.g., *сэхээтэн* 'intellectual'. In term formation, *-тан*⁴ is commonly used to create terms denoting plant and animal species. For example, in animal names — *битүү тууртан* 'odd-toed ungulates' (1); in plant names — *Луулийн язгууртан* 'Chenopodiaceae'; in names of microorganisms — *багц шилбүүртэн* 'lofotrihi' (1); in bird names — *жигүүртэн* 'birds', etc.

The suffix *-нцар* is primarily used to form terms with meaning 'diminutive', e. g., *үндсэнцэр* 'small root', *навчинцар* 'leaflets' (7); and meanings of similarity, e.g., *манинцар* 'hermaphroditism' (3), *болронцор чулуу* 'quartzite' (2), and the meaning 'piece of a big thing', e. g., *элэгний хэлтэнцэр* 'hepatic lobule' (2), etc. Thus, those are suffixes used for semantic extension of the vocabulary.

The study also reveals that the suffix *-гана*⁴ contains 5 different meanings when it comes to term formation: a) the suffix is mostly added to a noun to create one characterized by specific terminology of the subject. For example, *улаагана* 'red currant' (3), *хонхорт харгана* 'cingil silver' (3), *алтгана* 'golden karagana'; b) it is used to create terms denoting shape and form. For example, *өргөст бударгана* (*өргөст хамхуул*) 'Salsola pestifera Nels' (2); c) it is added to onomatopoeic words imitating animal sounds, such as *tsuur tsuur*, *hed hed* to create corresponding terms. For example, *цүүргэнэ* 'locust' (3), *хэдгэнэ* 'wasp' (3), etc. d) it is used to create term with the meaning of similarity. For example, *сүүгэнэ* 'Euphorbia' (1), *салаагана* 'chorispora' (2), *гичгэнэ* 'Potentilla bifurca' (1), e) it is added to roots of loan words to create new plant and fish names. For example, *тавилгана* — (*tavolga* + *гана*) (1), *Суладай, нагана* — *Нагана* (*Suladai, Nagana* — *Nagana*) (1), etc.

The second section of the paper mainly focuses on the frequency of the suffixes *-тан*⁴, *-нцар*², *-гана*⁴, *-лзай*³, *-ж*, *-жин*, *-ч*, *-чин*, *-ийнхан*² in the Russian-Mongolian Terminological Dictionary analyzed using the TextStat corpus linguistic software. The study concludes the suffix *-тан*⁴ to be traced 292 times in the structure of single and compound terms; *-нцар* — 218; *-гана* — 68; *-ч*, *-чин* — 53; *-ж*, *-жин* — 45; *-ийнхан* — 11.

Keywords: word-forming suffixes, formative terms, frequency use of suffixes, applied linguistics, changes of meanings